



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Онцгой амжилт гаргасан сурагчдыг  
шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтийг хангаж Таеквондогийн Улсын аварга шалгаруулах тэмцээн, Өсвөрийн шагайн харвайн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг шагнаж урамшуулсугай.

2. Шагналд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах 3,320,000 (гурван сая гурван зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД